



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/30

Мандалговь

Г Ажлын хэсэг томилох тухай Г


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Зава Дамдины нэрэмжилт бүтээн байгуулалт /Соёл амралтын хүрээлэнгийн тохижилт, Чагдаржавын талбайн гэрэлтүүлэг, тохижилт/-ын ажлын зураг төсвийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	О.Мөнхзул – ХОХБТХ-ийн мэргэжилтэн
Гишүүд:	Т.Эрдэнэбаяр – Зураг төсөл магадлал хариуцсан мэргэжилтэн
	Э.Энхмэнд – ГХБХБГ-ын мэргэжилтэн

Хоёр: Батлагдсан ажлын даалгаврын дагуу шаардлагад нийцсэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг ажлын хэсэг /О.Мөнхзул/ - т үүрэг болгосугай.

ДАРГА



О.ЧУЛУУНБАТ

0300079